# 「“ИТГЭЛ” ХАВДАРГҮЙ МОНГОЛ ҮНДЭСНИЙ САН」「ШИЗҮОКА МУЖИЙН ХАВДРЫН ТӨВ」 ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСЛОЛ

## 「がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金」「静岡県立静岡がんセンター」協定締結式

2016 он 3 сарын 5 өдөр（бямба）

2016年3月5日（土）




がんのないモンゴル“イトゲル−希望”国家基金と静岡県立静岡がんセンターは、2010年11月に締結した覚書に基づき、相互に関係を深めて参りました。

2016年3月、今日までの交流実績を踏まえ、覚書を発展的に解消し、新たに協定書を締結いたしました。

## 経緯

| | |
|---|---|
| 2010年8月 | ・静岡県知事がモンゴル国を訪問<br>・代表を務めていたモンゴル国大統領夫人が、がん問題に関心を寄せていることを知り、静岡がんセンターの視察を提案 |
| 2010年11月 | ・代表が静岡がんセンターを視察<br>・がんのないモンゴル“イトゲル−希望”国家基金と静岡がんセンターとの間でがんの予防・診断及び治療に関する協力などを定めた覚書を締結<br>（参考）モンゴル国大統領立会いの下で、モンゴル国ドルノゴビ県と静岡県の相互協力に関する覚書を締結。 |
| 2011年7月 | （参考）モンゴル国ドルノゴビ県と静岡県が友好協定を締結 |
| 2016年3月 | ・静岡がん会議2015の開催に合わせ、がんのないモンゴル“イトゲル−希望”国家基金と静岡がんセンターとの間でがん専門医師及び医療従事者の技術向上を目的とした研修に関する協力などを定めた協定書を締結 |




"Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизуока Мужийн Хавдар Судлалын Төв Эмнэлэгийн хооронд 2010 оны 11 сард тогтоосон "Санамж бичиг"-т тулгуурлан харилцан ажиллаж ирсэн.

2016 оны 3 сард өнөөдрийг хүртэл хамтран ажиллаж ирсэн туршлага дээрээ тулгуурлаж Санамж бичгийг харилцаагаа улам гүнзгийрүүлэх үүднээс цуцлаж шинээр "Гэрээ бичиг" болгон тогтоосон болно.

## Хамтарсан ажиллагааны түүх

| | |
|---|---|
| 2010.8 | ・ Шизуока мужийн Засаг дарга Монгол улсад айлчилав.<br>・ Монгол улсын тэргүүн хатагтай "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн тэргүүн болохыг мэдсэн Мужийн засаг дарга Шизуока Хавдар Судлалын төвд айлчлахыг урьсан. |
| 2010.11 | ・ "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн тэргүүн Шизуока Мужийн Хавдар Судлалын Төвд айлчилав.<br>・ "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизуока Мужийн Хавдар Судлалын Төвийн хооронд урьдчилсан шинжилгээ болон эмчилгээний салбарт хамтран ажиллах чиглэлээр харилцан тохиролцож, "Санамж бичиг" үзэглэв.<br>(жич) Монгол улсын Ерөнхийлөгчийн байлцан, Дорноговь аймаг, Шизуока мужийн хооронд мөн хамтран ажиллах "Санамж бичиг" тогтоосон. |
| 2011.7 | (жич) Монгол улсын Дорноговь аймаг, Шизуока мужийн хооронд найрамдалт харилцааны "Гэрээ бичиг" тогтоосон. |
| 2016.3 | ・ Шизуока мужийн "Хавдар судлалын хурал 2015" үйл ажиллагаатай давхцуулж "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизуока Мужийн Хавдар Судлалын Төвийн хооронд эмч, эрүүл мэндийн салбарын ажилтаны чадварыг дээшлүүлэх зорилгоор "Гэрээ бичиг" тогтоосон. |




## 協定締結式 概要

日　　時　2016年3月5日(土)　9:40～10:00

場　　所　静岡県立静岡がんセンター研究所1階　しおさいホール
（静岡県駿東郡長泉町下長窪1007）

締結案件　がんのないモンゴル“イトゲル－希望”国家基金と静岡県立静岡がんセンターとの協定

署 名 者　静岡県立静岡がんセンター総長　山口　建
がんのないモンゴル“イトゲル－希望”国家基金代表
ハジドスレン・ボロルマー
（モンゴル国大統領夫人）




## Гэрээ бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаа

Хугацаа: 2016 он 3 сарын 5 өдөр (бямба гариг) 9:40-10:00

Байршил: Шизуока Мужийн Хавдар Судлалын Төв Судалгааны байр, 1 давхар, Шиосай өрөө
(Шизуока мужийн Сүнто гүн Нагаизүми чё Шимонагакүбо 1007)

Агуулга: “Итгэл” Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизуока Мужийн хамтарсан ажиллагааны Гэрээ тогтоох тухай

Гарын үсэг: Шизуока Мужийн Хавдар Судлалын Төвийн Тэргүүн Ямагүчи Кэн
“Итгэл” Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн тэргүүн Хажидсүрэнгийн Болормаа
(Монгол Улсын Тэргүүн Хатагтай)



静岡県 知事

# 川勝 平太

本日は、「がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金」代表であるボロルマー　モンゴル国大統領夫人、モンゴル国の皆様方、企業や研究機関、行政の皆様方等、多くの方々に御参集賜りまして「静岡がん会議2015」を開催できますことに対し心から御礼申し上げます。

また、モンゴル国立がんセンターからラフガオチル先生、総務省からは行政評価局の評価監視官である佐分利様に特別講演を賜ること、加えて、ファルマバレー応援団代表の大川様からは基調講演を御快諾賜りましたこと、そして様々なシンポジウムやセミナー等々で講師をお引き受けくださいました方々に対しまして厚く御礼を申し上げます。

本日は、モンゴル国大統領夫人にお越しいただいております。6年前（平成22年（2010年）11月）に、「がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金（旧日本名称:HOPEがんのないモンゴル財団）」と静岡がんセンターの間で、がんの予防・診断及び治療に関する協力などを定めた覚書を締結しました。これをきっかけとして、以後、モンゴル国家大会議議員団の視察の受入れをはじめ、モンゴル語版の静岡がんセンター緩和ケアマニュアルや乳癌教育用視触診モデルの贈呈、モンゴル国医師の視察・研修の受入れなど、モンゴル国と本県は、極めて深い関係を築いております。加えて同年に、東京の迎賓館でエルベグドルジ大統領の立会いの下、ドルノゴビ県と静岡県との相互協力に関する覚書を交わしたことで、両県の関わりが極めて深くなりました。今やモンゴル国政府の産業省、食糧・農牧業省、教育・文化・科学省及び、保健・スポーツ省と本県が覚書を結ぶまでになっております。モンゴル国の人口は約300万人であり、人口が同規模である静岡県とは付き合いやすいということで、フレルバータル駐日モンゴル国特命全権大使からも、このモンゴル国と静岡県の関係をモデルとして、両国民の友好関係を深めたいという御希望を伺ったことがあるほどです。本日締結する協定は、これまでの実績を踏まえ、その中身を更に充実させるというものです。これを機縁にモンゴル国民の皆様方と静岡県民、ひいては日本国民の関係が更に良くなりますよう、強く希望いたします。

本会議は平成10年（1998年）に始まり本年で18回目を迎えました。当初は「静岡アジアがん会議」として5回開催し、参加者は数十名でしたが、平成15年（2003年）のファルマバレーセンター開設を機に「静岡がん会議」と名称を改め、「県民を中心にがんの治療を行う」、「臨床研究の成果の発表」、または「ファルマバレープロジェクトの推進」という目的で開催して参りました。ファルマバレープロジェクトは山口総長のリーダシップの下、第1次戦略計画、第2次戦略計画、第3次戦略計画と飛躍的に発展し、日本政府からは先端医療総合特区の指定も受けております。

さらに、この秋には長泉高等学校跡地に「静岡県医療健康産業研究開発センター」が全面オープンいたします。新しい拠点が作られ、本プロジェクトは新しい段階、次のステージに入ったということで、今回のテーマは「次のステージに向けて」としております。

ファルマバレーセンターは、しずおか産業創造機構（現:公益財団法人　静岡県産業振興財団）に属し、当初は6人しかいなかった職員が現在は40人になりました。完全に独り立ちするまでに至っており、正に静岡県の誇りです。本日は東海部品工業株式会社の盛田様にも御参加いただいておりますが、今や静岡県は医療機器生産額で日本一となりました。静岡県の健康寿命は、日本はもとより世界でもトップです。がんの研究や治験を通して、静岡県民はもちろんのこと、日本国民、そして我々の友人であるモンゴルの国民の皆様方、ひいては国籍を問わず困っている方々のために人類の健康を増進するという高い志で、静岡がん会議は開かれています。

本日は次のステージに向けての会議ということで、期待も高いものと存じます。本会議が素晴らしい成果を生みますことを祈念し、また、一貫して本会議を主導し、実行委員長を務めてこられました山口先生ほか、御準備いただいた方々に対して心から厚く御礼を申し上げまして、御挨拶といたします。 Баярлалаа（Bayarlalaa：ありがとうございます。）



Шизуока Мужийн Засаг Дарга

## Кавакацү Хэйта

Өнөөдөр "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн Тэргүүн, Монгол Улсын Тэргүүн Хатагтай Хажидсүрэнгийн Болормаа, Монгол Улсын эрхэм хүндэт зочид төлөөлөгчид, байгууллага, судалгааны төв болон төрийн захиргааны байгуулагын төлөөлөл та бүхэнд "Шизуока Хавдар Судлалын Хурал 2015" амжилттайгаар нээгдэж буйд баяртай байгаагаа илэрхийлье.

Монгол улсын хавдар судлалын төв эмнэлгээс оролцож буй Лхавга-Очир эмч болон Дотоод хэргийн яамны Сабүри төлөөлөгч, Эрүүл мэндийн Фармабарэ төслийн Оокава даргын илтгэлийг сонсох бөгөөд үргэлж хамтран ажиллаж байдаг та бүхэнд талархаж байна.

Өнөөдөр Монгол улсын Тэргүүн хатагтай морилон ирсэн зорилго нь 6 жилийн өмнө (2010.11) "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизуока Мужийн Хавдар Судлалын Төвийн хооронд Хорт хавдараас урьдчилан сэргийлэх болон эмчлэх зорилгоор "Санамж бичиг" тогтоосон ба үүний дараа Монгол улсын Их хурлын гишүүдийн төлөөлөл хүлээн авах, хөнгөвчлөх эмчилгээний гарын авлага монгол хэл дээр бэлтгэх, хөхний хавдар илрүүлэх сургалтын багаж төхөөрөмж, Монгол улсын эмч нарыг сургах гэх мэт олон чиглэлээр харилцан ажиллаж ирсэн юм. Мөн 2010 оны 11 сард Монгол улсын Ерөнхийлөгч байлцан, Токио хотын ноёдын ордонд Дорноговь аймаг, Шизуока мужийн хооронд хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг үзэглэснээр, бидний харилцаа улам гүнзгий дотно болж байна. Монгол улсын Аж үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэнд, спортын яамдуудтай Шизуока муж нь хамтарсан ажиллагааны "Гэрээ бичиг" тогтоогоод ажиллаж байна. Монгол улсын нийт хүн ам 3-н сая орчим бөгөөд Шизуока мужтай хамтран ажиллахад тохиромжтой байдаг билээ. Хүрэлбаатар элчин сайд хэлэхдээ Монгол улс, Шизуока мужийн найрамдалт харилцааг үлгэр дуурайл болгож хоёр улсын харилцааг хөгжүүлэх хэрэгтэй хэмээн хэлж байсныг дурьдахад таатай байна. Өнөөдөр тогтоогдох "Гэрээ бичиг"-ийн зорилго нь удаан хугацаанд хамтран ажиллаж ирсэн туршлага дээрээ тулгуурлаж, улам өргөжүүлэн батжуулах явдал юм. Энэхүү ажиллагааг хэрэгжүүлснээр Монгол улсын ард иргэд болон Шизуока мужийн ард иргэдийн харилцаа улам хөгжин дэвжихийг хүсэж байна.

Тус хурал нь 1998 оноос хойш өнөөдрийг хүртэл 18 жилийн турш тасралтгүй явагдаж ирсэн билээ. Анх "Шизуока-Ази Хавдар Судлалын Хурал" нэртэйгээр 5 жил зохион байгуулагдсан бөгөөд 10, 20-н хүний оролцоотойгоор явагддаг байсан бол 2003 оноос Фармабарэ эрүүл мэндийн төв цогцолбор барихтай холбогдуулан, "Шизуока Хавдар Судлалын Хурал" хэмээн нэрээ өөрчилж "Мужийн ард иргэдийн хорт хавдарыг голчлон эмчлэх", "Судалгааны шилжилгээний үр дүнгийн илтгэлүүд" мөн "Фармабарэ эрүүл мэндийн төв цогцолборын талаар танилцуулах" гэх мэт зорилгуудын хүрээнд зохион байгуулж ирсэн. Фармабарэ эрүүл мэндийн төв цогцолбор нь Ямагүчи ерөнхий захирлын удирдлага дор 1 дүгээрт Стратегийн төлөвлөгөө, мөн 2 дугаарт Стратегийн төлөвлөгөө, 3 дугаарт дахин Стратегийн төлөвлөгөөгөөр дамжин маш амжилттай хэрэгжиж, Япон улсын Засгийн газраас тогтоодог Эрүүл мэндийн тусгай бүсэд бүртгэгдээд байгаа юм. Удахгүй ирэх намар одоо ашиглагдахгүй байгаа Нагаизүми ахлах сургуулийн байранд "Шизуока мужийн эрүүл мэндийн үйлдвэрлэл судалгааг хөгжүүлэх төв"-ийг ашиглалтанд оруулахаар болоод байна. Шинэ төв ашиглалтанд орж тус Фармабарэ цогцолбор нь амжилттай хэрэгжиж, уг төсөл шинэ түвшинд гарч байгаа тул энэ удаагийн хурлын үндсэн сэдвийг "Дараагийн үе шат руу" хэмээн нэрийдсэн юм.

Анх Шизуока үйлдвэрлэлийн нийгэмлэгийн төвийн 6 ажилтантайгаар эхлүүлж байсан тус цогцолбор өдгөө 40 ажилтантай болсон байна. Энэ нь бие даасан нэг байгууллага болох бүрэн нөхцлийг хангасан гэж үзэхэд болох бөгөөд Шизуока мужийн нэгэн бахархал юм. Өнөөдрийн хуралд Тоокай бүхин коогёо ХХК-ийн Морита захирал оролцож байна. Эрүүл мэндийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ Шизуока муж нь Япон улсдаа №1 болоод байна. Хүн төрөлхтний эрүүл мэндийн гол зорилго нь эрүүл урт наслах явдал бөгөөд Шизуока мужийн иргэдийн эрүүл урт наслал нь Япон, Дэлхийн дээд түвшинд тооцогддог билээ. Хорт хавдар судлал болон эмчилгээгээр дамжуулж Шизуока мужийн ард иргэд, Япон улсын ард иргэд, бидний дотно анд болох Монгол улсын ард иргэд иргэншил хамааралгүйгээр зовж шаналж буй хүн нэг бүрийн төлөө бидний энэ Хавдар судлалын хурал маань нээгдэж байна.

“Дараагийн үе руу” дэвших зорилготойгоор нээгдэж буй энэ хурлаар маш өндөр хүлээлт, үр дүн гарна гэж бодож байна. Тус хурал нь өндөр үр дүнтэй ажиллагаа болохыг хүсэн ерөөхийн хамт тус хурлыг удирдан явуулах Ямагүчи ерөнхий захирал болон илтгэл тавих багш, эмч та бүхэнд дахин хүндэтгэл илэрхийлье.



がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金 代表
（モンゴル国大統領夫人）

## ハジドスレン・ボロルマー

静岡県知事 川勝平太様、静岡県立静岡がんセンター総長　山口建様とご臨席の皆様方に再びお会いできていることに感謝しております。そして私は再び皆様方と大自然の「ふじのくに」である静岡県でお会いできることに感謝をしております。

今まで、がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金と静岡県立静岡がんセンターとの間で様々な交流を進めて参りました。安定した交流を継続させるため、常にご尽力をくださいました静岡がんセンターの皆様と静岡県庁の方々へ改めてお礼を申し上げます。

静岡県がモンゴル国を代表する食料・農牧業省、保健・スポーツ省、産業省、教育・文化・科学省と地方自治体などの間で幅広く交流を進めていることに対して感謝の意を申し上げます。今までモンゴル国の各地から医師および医療従事者などの24名が本県を訪れ、研修プログラムなどに参加しております。

皆様方の温かい心の贈り物である、健診シュミレーター、緩和ケアマニュアルなどが中央研修センターだけではなく、へき地の緩和医療環境改善に効果を発揮しています。贈られた乳房健診シュミレーターは国立がんセンターで若手医師や医学生、そして女性の検診教育の機材として使われております。

毎年モンゴル国立がんセンターが地域で事前検診とがん知識を拡大するため、がん撲滅運動を開催しております。この際に、一番教育に直接つながるものとして検診シュミレーターが使われています。そして緩和ケアマニュアルは全国都道府県の医療機関などに配布されております。医師たちからは一番信頼を置く助っ人と言われていることを喜んでお伝えいたします。

私の国でも、世界が直面している病気の1つである悪性腫瘍が年々増加傾向にあります。それらは最終ステージの段階で診断されているケースが多く、この問題が私たちの心を痛めています。最終ステージに発見されている要因は、遊牧民の生活スタイル、そして患者本人の知識の薄さなどの結果と言われています。ですのでモンゴルのがん診断・治療に先進国の医療技術を逸早く取り入れることが必要不可欠と考えています。モンゴルの医師たちは学ぶ意欲に満ちております。

本日、協定の締結を以って相互の交流がさらに拡大し、モンゴルの医師および医療従事者が育成され、医療の新しい技術の獲得への協力できる道が整うことと思います。心から感激している次第です。これから広い分野で協力し、両国の博士、科学者、研究者らも共同で協議や研究活動などができる環境になりました。

私たちの友好的で親密な関係と公的な交流がさらに強固なものとなり、交流事業が高く発展することを祈念いたしますとともに、国民の健康のため日々努力を続けている医療関係者の皆様のご多幸をお祈り申し上げます。

どうもありがとうございます。



"ИТГЭЛ" Хорт Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн Тэргүүн
(Монгол улсын тэргүүн хатагтай)

# Хажидсүрэнгийн Болормаа

Эрхэмсэг ноён, мужийн захирагч Кавакацу Хейта танаа, Эрхэмсэг ноён, Хавдрын Төв эмнэлгийн дарга, доктор Ямагучи Кен танаа, Эрхэм Хүндэт та бүхний амар амгаланг эрж, сайн сайхныг хүсэн мэндчилье! Байгалийн үзэсгэлэнт Фүжи уулын өлгий нутаг Шизуока мужид ирж, Эрхэм Та бүхэнтэй дахин уулзаж байгаадаа баяртай байна.

Манай "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний Сан, Шизүока мужийн Хавдрын Төв эмнэлэг хооронд харилцаа, хамтын ажиллагаа тогтоосноос хойш бид багагүй ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Бидний энэ хамтын ажиллагаа тогтвортой, үр дүнтэй байх боломжийг бүрэн дэмжиж ажилласан мужийн захирагчийн алба, Хавдрын Төв эмнэлгийн хамт олон та бүхэнд гүн талархлаа илэрхийлье!

Түүнчлэн Шизуокачууд та бүхэн Монгол Улсын ХХААЯ, ЭМСЯ болон АУЯ, БСШУЯ-тай харилцаа тогтоон, хамтран ажиллах болсонд талархаж байгаагаа дахин илэрхийлье! Өнөөдрийг хүртэл манай улсын хот, хөдөөгийн хавдар судлаач эмч, мэргэжилтэн нийт 24 хүн Шизуока мужид зочлон, туршлага солилцох хөтөлбөрт хамрагджээ.

Мөн та бүхний халуун сэтгэлээр бэлэглэсэн сургалтын биет үзүүлэн болон хөнгөвчлөх эмчилгээний гарын авлага нь эмч нарын сургалтын бааз суурийг бэхжүүлэх, ялангуяа хөдөө орон нутагт хөнгөвчлөх эмчилгээний чанарыг сайжруулахад тодорхой үр дүнгээ өгч байна. Бид сургалтын биет үзүүлэнг ХСҮТ-д хүлээлгэн өгсөн ба өдгөө Анагаах Ухааны чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын журмаар, эмэгтэйчүүд, эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор тус тус ашиглагдаж байна.

Манай Хавдар Судлалын Үндэсний Төв жил бүр хөдөө, орон нутагт "Хавдрын эсрэг Үндэсний аян"-ыг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтын чиглэлээр зохион байгуулдаг билээ. Энэ үед сургалтын биет үзүүлэн нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролд нөлөөлсөн хамгийн бодит үзүүлэн болж чаддаг юм. Хөнгөвчлөх эмчилгээний гарын авлагыг 21 аймаг, 9 дүүргийн хавдар, хөнгөвчлөх эмчилгээний эмч нарт бүрэн тараасан ба эдүгээ эмч нарын маань хамгийн найдвартай туслагч нь болсоор байгааг дуулгахад таатай байна.

Дэлхий дахины тулгамдсан асуудал болсон хорт хавдар өвчнөөр өвчлөгсдийн тоо манай улсад жилээс жилд нэмэгдэж, хожуу үедээ оношлогдож байгаа нь бидний сэтгэлийг түгшээж байна. Энэ нь манай уламжлалт нүүдлийн соёл иргэншил, хувь хүний эрүүл мэндийн боловсролтой холбоотой ч Монголын хавдар судлалын салбарт оношилгоо, эмчилгээний шинэ арга техникийг нэвтрүүлэх, эмч мэргэжилтнүүдээ анагаах ухаан өндөр хөгжсөн улс орнуудад сургах шаардлагатай байна. Эмч нар маань ч суралцах хүсэл, эрмэлзэлэл дүүрэн байгаа юм.

Өнөөдөр энэхүү гэрээ бичгийг үзэгслэснээр бидний хамтын ажиллагаа улам өргөжиж, манай эмч мэргэжилтэнгүүдийг чадавхижуулах, эмчилгээний шинэ техник технологи эзэмшихэд нь дэмжих эрхзүйн орчин бүрдэж байгаад миний сэтгэл нэн өндөр байна. Цаашид бид өргөн хүрээнд хамтран ажиллаж, 2 орны эрдэмтэн, докторууд хамтарсан зөвлөгөөн, эрдэм шинжилгээний ажлыг ч хийх боломжтой боллоо.

Та бидний найрсаг, дотно харилцаа, ажил хэрэгч холбоо улам бүр батжиж, хамтын ажиллагаа маань өндөр түвшинд хөгжих болтугай! Хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө тууштай зүтгэгч, энэрэнгүй үйлсийн эзэд болсон та бүхэндээ сайн сайхан бүхнийг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе! Анхаарал тавьсанд баярлалаа.



静岡県立静岡がんセンター 総長
## 山口 建

本日ここにモンゴル国から、ファーストレディでもあられるボロルマー代表、そしてモンゴルの医師の方々やがんのないモンゴル“イトゲルー希望”国家基金の関係者の皆様にご出席いただき、これまでの覚書から新たな協定にレベルアップをする締結式に望みますことを、静岡がんセンター職員を代表して心から御礼申し上げます。さらにご陪席をいただいている川勝知事、およびファルマバレープロジェクトの推進に日頃大変お世話になっている地域の皆様方の前でこの協定が結ばれることに対しても大変感激しております。

本日は富士山は少し霞の中ですが、ちょうど河津桜が満開でモンゴルの方々をお迎えしております。振り返って数年間の両者の活動を見て参りますと、これまでモンゴル国から24名の方がお見えになっておりますが、そのうちの何名かの方が、「静岡で海を生まれて初めて見た」とおっしゃいました。一方で静岡がんセンターからモンゴル国に伺った職員は、「ゴビ砂漠の雄大さと本当に美しい星空に感動をした」と言って戻って参りました。双方で医療を越えた様々な交流が始まっている証左ではないかと思います。

医療に関しましては、初期の覚書締結後に、緩和ケア、あるいはがんの早期発見というところで活動が始まって参りました。新たな協定を締結した上で、モンゴルの最も多いがん、あるいは死因の第一位を成している肝臓がんの撲滅に向けての活動を静岡がんセンターもご協力させていただこうと考えております。

本年、日本国厚生労働省では、がん対策加速化プランが発表されておりますが、その中でもC型肝炎を中心とする肝炎対策が重要課題として位置付けられております。その1つの理由は、欧米での開発品ですが、C型肝炎に対する非常に有効な薬剤、慢性肝炎のレベルで治癒させる薬剤が開発され、ちょうど1年ほど前から日本でも広く保険適応になり、使われるようになったという経緯がございます。モンゴルでも同じ動きが始まっていると伺いましたので、肝炎や肝がん撲滅に向けた協力がこれから進められていくのではないかと思っております。

C型肝炎を中心とする肝臓疾患、特に最終的に肝臓がんになってしまった方の治療は消化器外科が担当します。消化器外科の幾つかの分野において、総合力では静岡がんセンターが世界一だと思います。静岡がんセンター開設から10年余りが経ち、食道外科、胃外科、大腸外科、肝・胆・膵外科のプロフェッショナルが日本を股にかけて活動しています。例えば、大腸がんのステージⅢという、かなり進んだ段階の治癒率も今や静岡がんセンターでは9割を超えておりますし、先般テレビの番組で肝・胆・膵外科の上坂副院長が取り上げられ、これもまた全国に感動を呼び、今この分野には全国から患者さんが集まってきているという状況になっております。

ですので、これから肝臓がんを中心に、予防や診断、それから治療を踏まえた一連のプロジェクトを進めることが可能と考えております。もちろん、抗がん剤治療や緩和ケアについても新たな試みを続けていきたいと考えています。

なお、本日この後、静岡県と静岡がんセンターが推進するファルマバレープロジェクトの最新の成果をお話しさせていただくわけですけども、そのあたりの状況も、本日、ご出席の皆様に知っていただくことが将来に向けて新たな展開につながるものと思っております。



Шизуока мужийн Хавдар Судлалын Төвийн Ерөнхий захирал

# Ямагүчи Кэн

Өнөөдөр Монгол улсаас Хажидсүрэнгийн Болормаа Тэргүүн хатагтай, Монгол улсын эмч нар мөн "ИТГЭЛ" Хорт Хавдаргүй Монгол Үндэсний Сангийн холбогдох ажилтан нарын оролцоотойгоор "Санамж бичиг" -ийн түвшинд явагдаж байсан хамтын ажиллагааг "Гэрээ бичиг" болгон хэрэгжүүлэх болсонд Шизуока Хавдар Судлалын Төвийн нийт ажилтнуудаа төлөөлж талархал илэрхийлье. Мөн өнөөдрийн ажиллагаанд хүрэлцэн ирсэн Кавакацү мужийн Засаг дарга болон Фармабарэ цогцолборын үйл ажиллагааг үргэлж дэмжин ажилладаг та бүхний өмнө "Гэрээ бичиг" тогтоогдох гэж буйд маш их баяртай байна.

Фүжи уул бага зэрэг манантай байгаа хэдий ч, Кавазү закүра цэцэг үзэсгэлэнтэйгээр дэлгэрч, Монгол улсын төлөөлөгчдийг угтаж байна. Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаануудаа эргэх харахад Монгол улсаас нийт 24 эмч хүлээн авсан ба эмч нарын дунд анх удаа далай харлаа гэсэн эмч байсан. Манай эмнэлгээс Монгол улсад ажилласан хүмүүс анх удаа говь хээрийн тал, үзэсгэлэнт оддыг харлаа гэж хэлдэг юм. Энэ утгаараа бид бүхний холбоо харилцаа эрүүл мэндийн салбарыг даван хөгжсөн нөхөрлөл гэхэд болох болов уу.

Эрүүл мэндийн салбарт анхны "Санамж бичиг" тогтоосноос хойш, хөнгөвчлөх эмчилгээний салбар болон эрт үед нь хорт хавдрыг илрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж ирсэн билээ. Шинээр "Гэрээ бичиг" тогтоосны дараа, Монголд хамгийн их байдаг хорт хавдар, нас баралтын гол шалтгаан болоод буй элэгний хорт хавдрыг дарах, эмчлэх чиглэлээр хамтран ажиллах бодолтой байна.

Энэ жил Эрүүл мэндийн яамнаас Хорт хавдрыг шуурхай илрүүлж, эмчлэх төлөвлөгөөг батлаад байгаа бөгөөд үүнд элэгний С вирусыг эмчлэх асуудал гол чиглэл болж байна. Европын улс орнуудад шинээр хийгдсэн элэгний С вирусын эм нь маш өндөр үр дүнтэй байгаа бөгөөд 1 жилийн өмнөөс даатгалд хамрагдан, эмчилгээнд хэрэглэгдэж байгаа билээ. Монголд мөн адилхан байдалтай явагдаж буй хэмээн сонссон тул энэ салбарт хамтран ажиллавал зүгээр болов уу гэж бодож байна.

Элэгний С вирусээр өвчилсөн хүмүүс, ялангуяа сүүлийн шатандаа хорт хавдар болсон тохиолдолд дотрын тасаг эмчилж байна. Хоол боловсруулах эрхтний мэс заслын хэд хэдэн хэсгүүд дээр манай эмнэлэг дэлхийд 1 дүгээрт орох хүчин чадалтай гэж дүгнэгддэг. Шизуока хавдар судлалын төв нь байгуулагдсанаас хойших 10 гаруй жилийн хугацаанд хоолой, элэг, бүдүүн гэдэсний болон элэг-цөс-бөөрний мэс заслуудыг маш өндөр түвшинд хийж байна. Тухайлбал: Бүдүүн гэдэсний хорт хавдар нь 3 дугаар шатандаа орсон хүнд өвчтнийг 90 хувь хүртэл бүрэн эмчилж байна. Мөн телевизээр элэг, бөөр, цөсний мэс заслын эмч Үэсака орлогч даргын талаарх баримтат нэвтрүүлэг бүх Япон орон даяар цацагдсан нь олон эмчлүүлэгчид ирэх нөхцлийг бүрдүүлсэн гэж бодож байна.

Элэгний хорт хавдрын эмчилгээг голчилж, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийж, түргэн шуурхай эмчилгээг хийх нь маш чухал гэж бодож байна. Мэдээж химийн эмчилгээ болон хөнгөвчлөх эмчилгээ үйлчилгээний шинэ аргуудыг судлан нэвтрүүлэх явдал туйлын чухал юм.

Өнөөдөр Шизуока муж, Шизуока мужийн хавдар судлалын төв хамтран хэрэгжүүлж буй Фармабарэ цогцолборын хамгийн сүүлийн үеийн үр дүн, ололт дэвшлийг та бүхэнд танилцуулах болно. Манай цогцолбор та бүхний ирээдүйн судалгаа, шинжилгээний ажилд нэгэн шинэ үр дүн, ололт нь байх болно гэдэгт итгэлтэй байна.

# 協定締結式の様子


静岡県立
静岡がんセンター
Shizuoka Cancer Center


ファルマバレープロジェクト ～次のステージに向けて～
「静岡県立静岡がんセンター」「がんのないモンゴル "イトゲル−希望" 国家基金」協定締結式
"ИТГЭЛ" ХАВДАРГҮЙ МОНГОЛ ҮНДЭСНИЙ САН ШИЗУОКА МУЖИЙН ХАВДРЫН ТӨВ
ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСЛОЛ










がんのないモンゴル "イトゲル−希望"
国家基金 代表
ハジドスレン・
ボロルマー


静岡県 理事
静岡県立静岡がんセンター 総長
山口　建


がんのないモンゴル "イトゲル-希望"
国家基金 代表
ハジドスレン・
ボロルマー


静岡県 理事
静岡県立静岡がんセンター 総長
山口　建




禁煙指導用モデル








Cancer Conference in Shizuoka 2015
静岡がん会議2015
ファルマバレープロジェクト
～次のステージに向けて～
会議プログラム

## 院内視察の様子










## Шизуока мужийн хавдар судлалын төвтэй танилцаж буй байдал











静岡新聞

26625号 （日刊）

静岡新聞

3月6日 日曜日

〒422-8033 静岡市駿河区登呂3-1-1
静岡新聞社
電話(054)282-1111
月決め2,900円（本体 2,685円 消費税 215円）
1部120円（消費税込み）
©静岡新聞社2016
浜松総局 浜松市中区旭町11-1 プレスタワー内 電話(053)455-3355
東部総局 沼津市魚町1 サンフロント内 電話(055)962-0380

県、静岡がんセンター

# モンゴル国家基金と協定

## 予防・診断・治療で協力

### 会議開催、ファルマ成果確認

県と県立静岡がんセンターは5日、「静岡がん会議2015」を長泉町の同センターで開いた。モンゴルのがん撲滅を目指す団体と、がんの予防・診断・治療での協力に関する協定を締結し、富士山麓に医療健康産業を集積させる県のファルマバレープロジェクトの成果や方向性を確認した。

同センターが協定を結んだのは、モンゴルの団体「がんのないモンゴル〝イトゲル―希望〟国家基金」（旧名称＝HOPEがんのないモンゴル）。同団体の要望で2010年に結んだ覚書を協定書に格上げすることを決め、団体の代表を務めるハジドスレン・ボロルマー＝モンゴル大統領夫人と同センターの山口建総長が、川勝平太知事の立ち会いの下、協定書に調印した。

同センターはこれまで、モンゴルの議員視察団の受け入れや緩和ケアマニュアル・乳がん教育用視触診モデルの提供などを続けてきた。山口総長は「モンゴルで多い肝臓がん撲滅に向けた活動に協力したい」と今後の方針を示した。

会議では同センターに近く1日、一部オープンしたプロジェクトの新拠点「県医療健康産業研究開発センター」も念頭に、関係省庁や企業の担当者約10人が、医療現場と連携した製品の開発などについて講演した。

協定締結式後、山口建総長（右）と握手するハジドスレン・ボロルマー夫人（左）。中央は川勝平太知事 ＝5日午前、長泉町の県立静岡がんセンター

地元の新聞に協定締結式の記事が掲載されました。

Хамтарсан ажиллагааны Гэрээ бичиг тогтоосон талаар Шизуока мужийн сонинд.

# 参考
# Товч танилцуулга

**日本国　静岡県立静岡がんセンターとモンゴル国　がんのないモンゴル**
**“イトゲルー希望”国家基金とのがん医療における協力に関する協定書**

日本国　静岡県立静岡がんセンターとモンゴル国　がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金（以下「両者」という。）は、2010年11月19日に締結した静岡県立静岡がんセンターとHOPEがんのないモンゴルとの覚書（以下「覚書」という。）に基づき、視察団の受け入れ、会議への医師等の参加、診療用資料の提供を実施してきた。

今後とも、両者が人類の福祉及び健康に資するとともに、保健分野における日本国とモンゴル国との二国間関係の一層の発展に寄与していくため、覚書を発展的に解消し、新たに次のとおり協定を締結する。

1　両者は、がんの予防、診断及び治療に関して相互に長期的かつ効果的な協力を行う。

2　両者は、がん患者のために高度な医学的見解が必要となった場合、それぞれの国におけるがん治療の専門知識及び技術に基づき、相互に相手方の医師にアドバイスを求め相談することができる。

3　両者は、がん専門の医師及び医療従事者の技術を向上させることを目的とした研修を行う。

4　両者は、がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金の派遣するモンゴル国医師が静岡県立静岡がんセンター主催の様々な会議やフォーラムに参加することに合意する。

5　両者は、それぞれががん患者及びその家族向けに作成した、がん予防や治療に関する様々な情報提供資料について、日本国及びモンゴル国の同じ立場の人々に提供できるよう、相互に供与しあう。

6　両者は、友好協力関係の着実な進展を図るため、必要な事項について別に協議する。

7　この協定書は、両者が日本語とモンゴル語で署名した後発効する。

2016年3月5日　日本国静岡県にて署名し、それぞれが一部を保持するものとする。

| | |
|---|---|
| 日本国 | モンゴル国 |
| 静岡県立静岡がんセンター | がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金 |
| 総　長 | 代　表 |
| 山口 建 | |

## МОНГОЛ УЛСЫН “ИТГЭЛ” ХАВДАРГҮЙ МОНГОЛ ҮНДЭСНИЙ САН, ЯПОН УЛСЫН ШИЗУОКА МУЖИЙН ХАВДАР СУДЛАЛЫН ТӨВ ХООРОНД ХОРТ ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БИЧИГ

“Итгэл” Хавдаргүй Монгол Үндэсний сан, Шизуока мужийн Хавдар Судлалын төв /цаашид “Талууд” гэх./ хооронд 2010 оны 11 сарын 19 өдөр үзэглэсэн Харилцан Ойлголцлын Санамж бичигт /цаашид “Санамж бичиг” гэх./ үндэслэн, Монгол эмч нарын төлөөллийг Шизуока мужийн Хавдар Судлалын төвд туршлага солилцох хөтөлбөр, онол практикийн хуралд оролцуулах болон гарын авлага солилцох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж ирсэн болно.

Цаашид Талууд хүн төрөлхтний эрүүл мэнд болон халамжинд хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүл мэндийн салбар дахь Монгол улс, Япон улсын харилцааны хөгжилд улам дэмжлэг үзүүлэх зорилгоор Санамж бичгийг цуцалж, дараахь зүйл заалт бүхий Гэрээ бичгийг шинээр байгуулав.

1. Талууд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаар урт хугацаанд үр өгөөжтэй хамтран ажиллана.
2. Талууд хорт хавдраар өвчилсөн өвчтөнд орчин үеийн анагаах ухааны мэдлэгт тулгуурласан санал, зөвөлгөөг өгөх ба шаардлагатай тохиолдолд, хоёр улс тус тусын хорт хавдрын эмчилгээний арга техник, технологид үндэслэн, хоёр талын эмч нар харилцан зөвлөгөө өгч, авч болно.
3. Талууд хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн эмч болон эмнэлгийн тусгай мэргэжилтэний сургалтыг зохион байгуулна.
4. Талууд “Итгэл” Хавдаргүй Монгол Үндэсний сангаас сонгогдсон Монгол улсын эмч нарыг Шизуока мужийн Хавдар Судлалын төвөөс зохион байгуулах онол практикийн хурал, чуулга уулзалтанд оролцуулж байхаар тохиролцов.
5. Талууд хорт хавдраас урьдчилан сэргийлэх болон хорт хавдартай өвчтөн түүний ар гэрийнхэнд зориулсан эрүүл ахуй, эмчлүүлэн, сувилах тухай төрөл бүрийн ном, товхимолыг боловсруулж харилцан солилцоно.
6. Талууд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг баттай хөгжүүлэхийн төлөө шаардлагатай бусад зүйлсийг тусгайлан хэлэлцэж шийдвэрлэнэ.
7. Энэхүү Гэрээ бичгийг Талууд Монгол, Япон хэл дээр хөрвүүлэн, тус тус гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

2016 оны 3 дугаар сарын 5-ний өдөр Япон улсын Шизуока мужид гарын үсэг зурж, тус тус 1 хувийг хадгалах болно.

| | |
|---|---|
| МОНГОЛ УЛС | ЯПОН УЛС |
| “Итгэл” Хавдаргүй Монгол Үндэсний сангийн Тэргүүн | Шизуока мужийн Хавдар Судлалын төвийн Тэргүүн |

## 1. がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金の概要

| | |
|---|---|
| 代　表 | ハジドスレン・ボロルマー（モンゴル国大統領夫人） |
| 創　立 | 2010年3月15日 |
| 目　的 | 国民的な健康問題であるがんの予防と治療について、立法・行政・市民団体・個人の注意を喚起し、問題解決のために全面的に支援・参画する。 |
| 活動内容 | (1) がんの予防活動の強化、がんのリスク要因削減について国民の啓発、ウェブサイトを通じた専門医の助言や情報の普及<br>(2) がんの診断と緩和ケアに関する最新技術の普及・啓発<br>(3) がん研究の医師・専門家の能力向上を目的とする外国研修への派遣<br>(4) 出産可能年齢の女性のがん発生要因の研究<br>(5) 首都・県の総合病院における緩和ケアサービスの促進を目的とするモデル診療科の創設<br>(6) がん予防・がん対策について国会・政府・非政府機関・市民運動・個人などと協力し、がん対策に特に貢献した個人・企業などを広く紹介する<br>(7) 内外の機関・支援者と協力して具体的なプロジェクト・プログラムの策定と実施、財源確保 |

## 2. 静岡県立静岡がんセンターの概要

| | |
|---|---|
| 代　表 | 総　長 山口　建<br>病院長 玉井　直 |
| 歴　史 | 1997年3月　「静岡がんセンター基本計画」策定<br>2002年4月　開設<br>2002年9月　診療開始<br>2006年8月　都道府県がん診療連携拠点病院に指定<br>2013年4月　特定機能病院に指定 |
| 理　念 | 基本理念:患者さんの視点の重視<br>理念（患者さんへの約束）<br>○ がんを上手に治す<br>○ 患者さんと家族を徹底支援する<br>○ 成長と進化を継続する |
| 活動内容 | (1) 病床数　611床<br>(2) 診療実績（2015年度）<br>入院延べ患者数　188,902人<br>外来延べ患者数　281,785人<br>手術件数　4,648件 |

## 3. 詳細な交流実績

### (1)静岡がんセンターへの視察受入れ

| 時　期 | 視察団 | 人数(人) |
|---|---|---|
| 2011.10 | モンゴル国家大会議議員団 | 4 |
| 2012. 2 | ドルノゴビ県人民会議議員団 | 5 |
| 2013. 4 | ドルノゴビ県副知事ほか | 2 |
| 2013.11 | モンゴル国立第三病院副院長ほか | 4 |
| 2014. 2 | ドルノゴビ県医療指導センター課長 | 1 |

### (2)静岡がん会議へのモンゴル国医師等の招へい

| 時　期 | 招へい者(所属) |
|---|---|
| 2011.2.19 | バタゾリゲ・バーサンジャワ(モンゴル国立がんセンター) |
| 2012.3.20 | バタゾリゲ・バーサンジャワ(モンゴル国立がんセンター)<br>ジギジドスレン・チンブレン(モンゴル国立がんセンター)<br>ダグダン・ヤガーン(モンゴル国立がんセンター)<br>バトフウ・オトゴンバヤル(サインシャンド市中央病院)<br>エルデン・エルベグドルジ(国家基金※専務理事) |
| 2013.3.9 | ジャザガ・アマルサナー(保健省副大臣)<br>レンドー・ダワードルジ(モンゴル国軍病院長)<br>エンフトゥル・アマルサナー(ウランバートルがんセンター)<br>オユーンツェツェグ・ムンフツゥツェグ(ドルノゴビ県中央病院) |
| 2014.3.8 | ダルマー・ガンチメグ(国立母子健康センター付属小児科病院)<br>ナムサライ・バダム(オブス県婦人科腫瘍専門医)<br>ゴンボドルジ・サランツェツェグ(ドルノド県腫瘍緩和ケア医)<br>プレヴスレン・ブレンジャルガル(ドルノゴビ県中央病院) |
| 2015.3.7 | ルブサンサンボー・トゥムルバートル(モンゴル国立がんセンター院長)<br>ヤダムスレン・エルデネトヤ(モンゴル国立がんセンター)<br>スリナ・ソロンゴ(ウランバートル市ハンオール区保健センター)<br>マンタイノロヴ・ナランツェツェグ(ドルノゴビ県中央病院) |
| 2016.3.5 | ハジドスレン・ボロルマー(国家基金※代表(モンゴル国大統領夫人)<br>サンボ・ナランゲレル(国家基金※秘書)<br>トヴ・ラフガオチル(モンゴル国立がんセンター)<br>ラムジャヴ・ムングンツェツェグ(モンゴル国立がんセンター)<br>ツァガーン・ナラントヤ(アセ婦人総合病院)<br>サンジミャタヴ・バヤルスヴダ(国家基金※) |

※国家基金…がんのないモンゴル“イトゲルー希望”国家基金の略

## 1. “ИТГЭЛ” Хавдаргүй Монгол Үндэсний сангийн товч танилцуулга

| | |
|---|---|
| Тэргүүн | Хажидсүрэнгийн Болормаа ( Монгол улсын тэргүүн хатагтай) |
| Байгуулагдсан он сар өдөр | 2010 оны 3 дугаар сарын 15 ны өдөр |
| Зорилго | Хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох хорт хавдар түүнээс урьдчилан сэргийлэх, хорт хавдартай тэмцэх үйл ажиллагаанд шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, олон нийтийн байгууллага, иргэдийн анхаарлыг хандуулж тухайн асуудлыг шийдвэрлэхэд бүхий л талын дэмжлэг оролцоог бий болгоно. |
| Танилцуулга | (1) Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хорт хавдар үүсгэгч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар иргэдэд мэдээ, мэдээллийг нээлттэй хүргэх, вэб хуудсаар дамжуулан мэргэжлийн эмч нарын зөвлөмж, мэдээллийг түгээх<br>(2) Хавдрын оношлогоо, эмчилгээнд гарч байгаа сүүлийн үеийн ололт, дэвшил, шинэ техник технологийг улс орондоо нэвтрүүлэх, сурталчлах<br>(3) Хавдар судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор гадаад улс оронд шинэ ур чадвар эзэмших сургалтанд хамруулах<br>(4) Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд тохиолдож буй хавдар, түүний урьдал хүчин зүйлийг судлах<br>(5) Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлгүүдэд хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор загвар тасгийн стандартын дагуу байгуулан ажиллуулах<br>(6) Хорт хавдраас сэргийлэх, хавдартай тэмцэх талаар шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид болон мөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ, олон нийтийн үүсгэл санаачлага бүхий хөдөлгөөн, хувь хүнтэй хамтран ажиллах, хавдартай тэмцэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон нийтэд мэдээлж тэднийг АЛДАРШУУЛАХ арга хэмжээг санаачлан зохион байгуулах<br>(7) Гадаад, дотоодын байгууллага, хандивлагчидтай хамтран ажиллаж тодорхой төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, шалгагдах хөрөнгө, санхүүжилт бий болгоход бүхий л талаар эрэлхийлэн ажиллана. |

## 2. Шизуока мужийн Хавдар судлалын төвийн товч танилцуулга

| | |
|---|---|
| Тэргүүн | Ерөнхий захирал Ямагүчи Кэн<br>Дэд захирал Тамай Сүнао |
| Түүх | 1997 он 3 сар "Шизуока Хавдар судлалын төв" байгуулах шийдвэр<br>2002 он 4 сар Шизуока Хавдар судлалын төвийн нээлт<br>2002 он 9 сар Эмчилгээ эхлүүлсэн<br>2006 он 8 сар Хавдрын төрөлжсөн эмчилгээ явуулах төв эмнэлэг<br>2013 он 4 сар Тусгай зөвшөөрөл бүхий эмнэлэг |
| Зорилго | Үндсэн зорилго: Эмчлүүлэгчийн байр сууринаас хандах<br>Зорилго (Эмчлүүлэгчид өгөх амлалт)<br>◦ Хорт хавдрыг амжилттай бүрэн эмчлэх<br>◦ Эмчлүүлэгч болон гэр бүлийг нь бүрэн дэмжих<br>◦ Тогтвортой зогсолтгүй хөгжих |
| Үйл ажиллагааны чиглэл | (1) Эмнэлгийн ор 611ор<br>(2) Эмчилгээний байдал (2015 оны санхүүгийн жилд)<br>Хэвтэж эмчлүүлэгч 188,902 хүн<br>Өдрөөр эмчлүүлэгч 281,785 хүн<br>Мэс заслын тоо 4,648 мэс засал |

## 3. Хамтарсан ажиллагааны тодорхой мэдээлэл

(1) Шизуока мужийн Хавдар судлалын төв Монгол улсаас хүлээн авсан эмч нар

| Он сар | Төлөөлөгчид | Хүний тоо |
|---|---|---|
| 2011.10 | Монгол улсын Их хурлын гишүүд | 4 |
| 2012. 2 | Дорноговь аймгийн ИТХ ын гишүүд | 5 |
| 2013. 4 | Дорноговь аймгийн засаг даргын орлогч | 2 |
| 2013.11 | Монгол улсын 3 дугаар эмнэлэгийн төлөөлөл | 4 |
| 2014. 2 | Дорноговь аймгийн Төв эмнэлэгийн дарга | 1 |

(2) Шизуока хавдар судлалын хуралд Монгол улсаас урьж оролцуулсан эмч нар

| Он сар өдөр | Төлөөлөгчид |
|---|---|
| 2011.2.19 | Батзориг Баасанжав (Монгол улсын Хавдар судлалын төв) |
| 2012.3.20 | Батзориг Баасанжав (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Жигжидсүрэн Чинхүлэн (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Дагдан Ягаан (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Батхүү Отгонбаяр (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Элбэгдорж Эрдэнэ (ИТГЭЛ Хавдаргүй Монгол Үндэсний сан гүйцэтгэх захирал) |
| 2013.3.9 | Жазаг Амарсанаа (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Рэндо Даваадорж (Монгол улсын Цэргийн их эмнэлэг)<br>Энхтөр Амарсанаа (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Оюунцэцэг Мөнхцэцэг (Дорноговь аймгийн төв эмнэлэг) |
| 2014.3.8 | Дармаа Ганчимэг (Монгол улсын хүүхдийн эмнэлэг)<br>Намсрай Бадам (Увс аймгийн эмэгтэйчүүдийн эмнэлэг)<br>Гомбодорж Саранцэцэг (Дорноговь аймгийн төв эмнэлэг)<br>Пүрэвсүрэн Бүрэнжаргал (Дорноговь аймгийн төв эмнэлэг) |
| 2015.3.7 | Лувсансамбуу Төмөрбаатар (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Ядамсүрэн Эрдэнэтуяа (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Сүрэн Солонго (Улаанбаатар хотын Хануул дүүргийн эмнэлэг)<br>Мантайноров Наранцэцэг (Дорноговь аймгийн төв эмнэлэг) |
| 2016.3.5 | Хажидсүрэн Болормаа (ИТГЭЛ сангийн тэргүүн (Монгол улсын тэргүүн хатагтай))<br>Самбуу Нарагэрэл (ИТГЭЛ сангийн нарийн бичиг)<br>Товуу Лхавгаочир (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Лхамжав Мөнхцэцэг (Монгол улсын Хавдар судлалын төв)<br>Цагаан Нарантуяа (АСЭ эмэгтэйчүүдийн эмнэлэг)<br>Санжмятав Баярсувд (ИТГЭЛ сан) |